

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/095/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Гурав. Аудитын илрүүлэлт

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.25 № 107

танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БУЯНЗАЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй. Үүнд:

- Жилийн эцсийн тооллогоор 264,210.6 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооцоо бодоогүй,
- Төсөвт байгууллагуудын гадна засварын 25,000.0 мянган төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулахдаа нэг гүйцэтгэгчтэй 12,000.0 мянган төгрөг болон 13,000.0 мянган төгрөгөөр шууд гэрээ байгуулсан,
- Тайлант онд ажилтанд олгосон цалингийн урьдчилгаа 3,000.0 мянган төгрөгийг дутуу суутгаж авлагаар тайлагнасан,
- Буудлын өрөө болон спорт заалны орлогоос 2,165.0 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлсэн боловч өөрийн орлогыг төлөвлөдөггүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.7 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, 24 дүгээр зүйлийн 24.4, 27 дугаар зүйлийн 27.1.7, 42 дугаар зүйлийн 42.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3, Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5, Төрийн

822505000317

хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6, 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллагын орон нутгийн төсвийн санхүүжилт өмнөх оноос 18,236.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд тус сумын нутаг дэвсгэрт хүчтэй шуурга шуурч гамшгийн хэмжээнд хүрсэн бөгөөд төсөвт байгууллагуудын сэргээн засварлах засварын зардалд 146,511.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагчийн 8 зорилтын хүрээнд 206 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 2 арга хэмжээг 30.0 хувьтай хэрэгжүүлж, 204 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 97.5 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөг)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	8,024,420.00	27,344,453.61
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	408,000.00	3,000,000.00
335	Бусад авлага	7,616,420.00	24,344,453.61
33510	Байгууллагаас авах авлага	6,000,000.00	1,844,453.61
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,616,420.00	22,500,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,500,000.00	-
3471	Урьдчилгаа тооцоо	1,500,000.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	1,500,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	187,144,620.27	264,210,620.27
351	Түүхий эд материал	11,263,600.00	27,791,600.00
35110	Тусгай зориулалттай материал	11,263,600.00	27,791,600.00
354	Хангамжийн материал	71,891,020.27	82,429,020.27
35410	Бичиг хэргийн материал	2,758,600.00	2,993,600.00
35420	Аж ахуйн материал	47,537,201.25	56,990,201.25
35430	Сэлбэг хэрэгсэл	3,946,500.00	4,796,500.00
35450	Барилгын засварын материал	2,357,600.00	2,357,600.00
35470	Бусад хангамжийн материал	15,291,119.02	15,291,119.02
35600	Мал амьтад	103,990,000.00	153,990,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	196,669,040.27	291,555,073.88
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,528,902,667.09	5,446,021,376.01
392	Биет хөрөнгө	3,294,265,987.09	4,209,593,376.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,520,467,474.89	4,618,810,256.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(693,418,630.62)	(1,049,842,386.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	227,753,400.00	308,715,209.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(164,336,133.10)	(190,372,573.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	160,316,155.04	184,565,042.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(101,702,796.49)	(121,312,768.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,593,025.60	110,264,025.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,710,057.38)	(60,794,204.93)
39209	Зам, гүүрийн байгууламж	143,701,762.00	173,601,762.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(40,216,671.33)	(50,398,626.20)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10,000,000.00	10,000,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	277,660,991.00	422,616,826.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(99,842,532.52)	(146,259,185.86)
393	Биет бус хөрөнгө	1,234,636,680.00	1,236,428,000.00
39301	Програм хангамж	9,402,680.00	110,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,225,234,000.00	1,236,318,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,528,902,667.09	5,446,021,376.01
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,725,571,707.36	5,737,576,449.89
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,108,842.40	16,701,880.00
413	Өглөг	42,108,842.40	16,701,880.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	40,621,438.11	-
4136	Бусад өглөг	1,487,404.29	16,701,880.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,487,404.29	16,701,880.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	42,108,842.40	16,701,880.00
51	Засгийн газрын хувь оролцоо	4,683,462,864.96	5,720,874,569.89

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	196,494,040.37	196,494,040.37
511001	Засгийн газрын оруулсан капитал загийн газрын сан	196,494,040.37	196,494,040.37
512	Хуримтлагдсан үр дүн	4,282,356,058.16	5,319,767,763.09
51210	Өмнөх үеийн үр дүн	3,321,624,291.74	4,282,357,378.16
51220	Тайлант үеийн үр дүн	960,731,766.42	1,037,410,384.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	204,612,766.43	204,612,766.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,683,462,864.96	5,720,874,569.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,725,571,707.36	5,737,576,449.89

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,324,890,307.00	1,225,152,197.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,499,007.00	62,523,997.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	177,508,007.00	56,210,997.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,991,000.00	6,313,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,144,391,300.00	1,162,628,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,144,391,300.00	1,162,628,200.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	1,085,098,910.45	1,469,740,313.01
120	Нийтлэг татварын бус орлого	1,085,098,910.45	1,469,740,313.01
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,071,505,910.45	1,396,870,313.01
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,593,000.00	72,870,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,409,989,217.45	2,694,892,510.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,534,573,627.27	1,657,482,125.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,424,759,231.13	1,552,769,969.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607,425,737.82	583,498,068.86
210101	Үндсэн цалин	378,467,768.54	386,383,991.77
210102	Нэмэгдэл	190,193,501.99	188,807,077.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,218,983.39	8,307,000.00
210104	Урамшуулал	28,545,483.90	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,062,859.85	75,472,213.66
210201	Тэтгэврийн даатгал	51,638,176.91	56,558,708.83
210202	Тэтгэмжийн даатгал	6,075,079.66	4,848,774.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,161,904.16	2,453,006.99
210204	Ажилгүйдлийн даатгал	3,037,539.83	2,322,344.76
210205	Эрүүл мэндийн даатгал	12,150,159.29	9,289,379.08

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,815,548.59	179,952,402.84
210301	Гэрэл, цахилгаан	15,411,228.59	25,913,862.84
210302	Түлш, халаалт	108,328,000.00	151,659,200.00
210303	Цэвэр, бохир ус	5,076,320.00	2,379,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	79,295,577.00	63,104,578.00
210401	Бичиг хэрэг	6,283,925.00	3,145,950.00
210402	Тээвэр, шатахуун	65,814,252.00	52,721,898.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,376,500.00	1,713,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	598,400.00	298,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,222,500.00	5,224,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,996,750.00	3,121,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	175,000.00	-
210604	Урсгал засвар	10,821,750.00	3,121,100.00
2107	Томилолт, зочны зардал	10,956,000.00	3,490,000.00
210702	Дотоод албан томилолт	10,956,000.00	3,490,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,707,295.00	54,307,605.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,794,100.00	51,141,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	125,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,044,800.00	880,000.00
210807	Газрын төлбөр	1,747,395.00	2,160,705.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	492,499,462.87	589,824,001.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	174,522,200.00	104,071,077.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,284,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	312,693,262.87	485,752,924.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,814,396.14	104,712,155.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,113,800.60	55,482,603.80
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,635,144.60	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,531,156.00	52,735,603.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,947,500.00	2,747,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,700,595.54	49,229,551.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,700,595.54	49,177,948.83
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	51,603.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,534,573,627.27	1,657,482,125.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	875,415,590.18	1,037,410,384.92
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	875,415,590.18	1,037,410,384.92

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,324,890,307.00	1,225,152,197.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	180,499,007.00	62,523,997.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	177,508,007.00	60,323,997.00

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,991,000.00	2,200,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,144,391,300.00	1,162,628,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,144,391,300.00	1,162,628,200.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,324,890,307.00	1,225,152,197.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,204,976,772.00	1,225,152,197.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,095,162,375.86	1,120,440,041.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	577,445,500.00	620,678,543.04
210101	Үндсэн цалин	348,487,530.72	423,564,465.95
210102	Нэмэгдэл	190,193,501.99	188,807,077.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,218,983.39	8,307,000.00
210104	Урамшуулал	28,545,483.90	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,421,659.56	80,148,782.20
210201	Тэтгэврийн даатгал	45,523,271.67	56,708,982.30
210202	Тэтгэмжийн даатгал	4,950,994.48	5,972,859.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,569,907.24	3,045,003.91
210204	Ажилгүйдлийн даатгал	2,475,497.24	2,884,387.35
210205	Эрүүл мэндийн даатгал	9,901,988.93	11,537,549.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	128,329,644.30	164,197,327.13
210301	Гэрэл, цахилгаан	14,925,324.30	26,860,667.13
210302	Түлш, халаалт	108,328,000.00	134,957,320.00
210303	Цэвэр, бохир ус	5,076,320.00	2,379,340.00
2104	Хангамж, бараа материалын зардал	80,397,627.00	62,233,363.00
210401	Бичиг хэрэг	7,064,925.00	3,380,950.00
210402	Тээвэр, шатахуун	64,812,752.00	52,396,683.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,376,500.00	1,713,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	598,400.00	298,480.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,545,050.00	4,443,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,771,750.00	4,981,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	405,000.00	-
210604	Урсгал засвар	14,366,750.00	4,981,100.00
2107	Томилолт, зочны зардал	10,956,000.00	3,490,000.00
210702	Дотоод албан томилолт	10,956,000.00	3,490,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,707,295.00	54,467,605.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,794,100.00	51,301,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	125,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,044,800.00	880,000.00
210807	Газрын төлбөр	1,747,395.00	2,160,705.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	193,132,900.00	130,243,321.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	187,848,900.00	130,243,321.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,284,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	109,814,396.14	104,712,155.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	89,113,800.60	55,482,603.80
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	35,635,144.60	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,531,156.00	52,735,603.80

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,947,500.00	2,747,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	20,700,595.54	49,229,551.83
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,700,595.54	49,177,948.83
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		51,603.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	1,204,976,772.00	1,225,152,197.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	119,913,535.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	119,913,535.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	119,913,535.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	119,913,535.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	119,913,535.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(119,913,535.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөг)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	3,321,624,291.74	3,722,731,098.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	3,321,624,291.74	3,722,731,098.54
C09	Тайлант үеийн үр дүн	-	-	960,731,766.42	960,731,766.42
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	4,282,356,058.16	4,683,462,864.96
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	4,282,356,058.16	4,683,462,864.96
C12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,320.00	1,320.00
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	4,282,357,378.16	4,683,464,184.96
C19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,037,410,384.92	1,037,410,384.92
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,494,040.37	204,612,766.43	5,319,767,763.09	5,720,874,569.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Цэвэр гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,162,628,200.00	1,113,450,251.17	49,177,948.83	96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,162,628,200.00	1,113,450,251.17	49,177,948.83	96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,105,278,200.00	1,057,967,647.37	47,310,552.63	96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	620,724,100.00	620,678,543.04	45,556.96	100
210101	Үндсэн цалин	620,724,100.00	423,564,465.95	197,159,634.05	68
210102	Нэмэгдэл	-	188,807,077.09	(188,807,077.09)	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	8,307,000.00	(8,307,000.00)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,480,400.00	80,148,782.20	331,617.80	100
210201	Тэтгэврийн даатгал	53,031,400.00	56,708,982.30	(3,677,582.30)	107
210202	Тэтгэмжийн даатгал	5,854,500.00	5,972,859.18	(118,359.18)	102
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,948,700.00	3,045,003.91	3,903,696.09	44
210204	Ажилгүйдлийн даатгал	2,906,800.00	2,884,387.35	22,412.65	99
210205	Эрүүл мэндийн даатгал	11,739,000.00	11,537,549.46	201,450.54	98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,058,100.00	164,197,327.13	12,860,772.87	93
210301	Гэрэл, цахилгаан	39,700,000.00	26,860,667.13	12,839,332.87	68
210302	Түлш, халаалт	134,958,100.00	134,957,320.00	780.00	100
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,379,340.00	20,660.00	99
2104	Хангамж, бараа материалын зардал	65,983,600.00	56,404,060.00	9,579,540.00	85
210401	Бичиг хэрэг	4,866,800.00	3,380,950.00	1,485,850.00	69
210402	Тээвэр, шатахуун	52,666,800.00	48,117,380.00	4,549,420.00	91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	1,158,500.00	341,500.00	77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	900,000.00	298,480.00	601,520.00	33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,050,000.00	3,448,750.00	2,601,250.00	57
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,900,000.00	3,666,100.00	233,900.00	94
210604	Урсгал засвар	3,900,000.00	3,666,100.00	233,900.00	94
2107	Томиллолт, зочны зардал	4,800,000.00	3,490,000.00	1,310,000.00	73
210702	Дотоод албан томиллолт	4,800,000.00	3,490,000.00	1,310,000.00	73
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,932,000.00	4,627,605.00	5,304,395.00	47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,300,000.00	1,461,500.00	3,838,500.00	28
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	125,400.00	74,600.00	63
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	-	400,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,760,000.00	880,000.00	880,000.00	50
210807	Газрын төлбөр	2,200,000.00	2,160,705.00	39,295.00	98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	142,400,000.00	124,755,230.00	17,644,770.00	88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,400,000.00	124,755,230.00	17,644,770.00	88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,350,000.00	55,482,603.80	1,867,396.20	97
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,350,000.00	55,482,603.80	1,867,396.20	97
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,100,000.00	52,735,603.80	364,396.20	99

**Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,250,000.00	2,747,000.00	1,503,000.00	65
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,162,628,200.00	1,113,450,251.17	49,177,948.83	96
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,162,628,200.00	1,113,450,251.17	49,177,948.83	96
132001	Орон нутгийн төсвөөс	1,162,628,200.00	1,113,450,251.17	49,177,948.83	96
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-		

2.6 НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН (төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,523,997.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,523,997.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	62,472,394.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,829,303.00
210402	Тээвэр, шатахуун	4,279,303.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	555,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	995,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,315,000.00
210604	Урсгал засвар	1,315,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,840,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,840,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,488,091.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,488,091.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,603.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,603.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,603.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,523,997.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,523,997.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	60,323,997.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,200,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. Аудитын илрүүлэлт

3.1 Аудитаар 308,833.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 286,333.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
ГAA-2026/095/НА-СТА-ТШЗ

- **НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой:** Тайлант онд дуусаагүй ажлын 22,500.0 мянган төгрөгийн урьдчилж олгосон санхүүжилтийг тайлант үеийн зардлаар тайлагнасан.

Залруулагдаагүй 31,313.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 31,313.1 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрч 2 зөвлөмж, 2 зөрчил албан шаардлага, 2 төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Төлбөрийн акт

1. Тайлант онд ажилтанд олгосон цалингийн урьдчилгаанаас 3,000.0 мянган төгрөгийг дутуу суутгаж авлагаар тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн урьдчилгааг төлүүлж, төсөвт төвлөрүүлэх.

2. Ажилтантай 477.9 мянган төгрөгийн амралтын цалингийн дуусгалтын тооцоо хийлгүйгээр ажлаас чөлөөлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 477.9 мянган төгрөгийн цалинг төлүүлж, төсвийн орлого болгох.

3.3 Албан шаардлага

1. Төсөвт байгууллагуудын гадна засварын ажлыг нийт 25,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахдаа шууд гэрээ байгуулах зорилгоор нэг гүйцэтгэгчтэй 12,000.0 мянган төгрөг болон 13,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно". гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Жилийн эцсийн тооллогоор 264,210.6 мянган төгрөгийн бараа материалыг тоолоогүй, тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.3-т "Төрийн өмчийн хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хуульд заасан хугацаанд болон зайлшгүй шаардлагатай үед хийнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллогыг тогтоосон хгацаанд чанартай гүйцэтгэж биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Орлогын бүрдүүлэлттэй холбоотой

Засаг даргын Тамгын газар нь тайлант онд буудлын өрөө болон спорт заалны орлогоос 2,165.0 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлж, өөрийн орлогын эх үүсвэр байгаа боловч төлөвлөхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж ажиллах.

Хоёр: Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

Сумын Засаг даргын Тамгын газрын даргад нотариатын ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг үндсэн цалингийн 10.0, 20.0 хувиар тооцож 670.2 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-т "Нотариатч энэ хуульд зааснаас бусад үйлчилгээний хөлс, зардал болон шагнал, урамшуулал авахыг хориглоно", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндэслэлгүйгээр нэмэгдэл хөлс олгож байгаа зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 286,333.2 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.	1	286,333.2	1	286,333.2	-	-	1	286,333.2	-	-	-	-
	Тайлант онд дуусаагүй ажлын 22,500.0 мянган төгрөгийн урьдчилж олгосон санхүүжилтийг тайлант үеийн зардлаар тайлагнасан.	1	22,500.0	1	22,500.0	--	-	1	22,500.0				
Дүн		2	308,833.2	2	308,833.2	-	-	2	308,833.2	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг	Тайлант онд ажилтанд олгосон цалингийн урьдчилгаанаас 3,000.0 мянган төгрөгийг дутуу суутгаж авлагаар тайлагнасан.	1	3,000.0	1	3,000.0							
	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтантай 477.9 мянган төгрөгийн амралтын цалингийн	1	477.9	1	477.9							

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

даргын Тамгын газар	дуусгалтын тооцоо хийлгүйгээр ажлаас чөлөөлсөн байна.										
	Төсөвт байгууллагуудын гадна засварын ажлыг нийт 25,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахдаа шууд гэрээ байгуулах зорилгоор нэг гүйцэтгэгчтэй 12,000.0 мянган төгрөг болон 13,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулсан.	1	25,000.0			1	25,000.0				
	Жилийн эцсийн тооллогоор 264,210.6 мянган төгрөгийн бараа материалыг тоолж, тооцоо бодоогүй байна.	1	-			1	-				
	Засаг даргын Тамгын газар нь тайлант онд буудлын өрөө болон спорт заалны орлогоос 2,165.0 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлөрүүлж, өөрийн орлогын эх үүсвэр байгаа боловч төлөвлөдөггүй байна.	1	2,165.0					1	2,165.0		
	Нотариатын үйлчилгээний нэмэгдлийг үндсэн цалингийн 10.0, 20.0 хувиар тооцож 670.2 мянган төгрөгийг олгосон.	1	670.2					1	670.2		
Нийт		6	31,313.1	2	3,477.9	2	25,000.0	2	2,835.2		